



## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 09 сарын 03 өдөр

Дугаар А/277.

Улаанбаатар хот

Хан-Уул дүүргийн Насан туршийн суралцахуйн төвийн эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн наймдугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хан-Уул дүүргийн Насан туршийн суралцахуйн төвийн эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 7,991,115.00 (долоон сая есөн зуун ерэн нэгэн мянга нэг зуун арван таван) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Хан-Уул дүүргийн Насан туршийн суралцахуйн төв (Т.Рэгзэдмаа)-д зөвшөөрсүгэй.

2. Татан төвлөрүүлэхээр шийдвэрлэсэн 9 нэр төрлийн нийт 7,991,115.00 (долоон сая есөн зуун ерэн нэгэн мянга нэг зуун арван таван) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Нийслэлийн өмчийн харилцааны газарт актаар хүлээлгэн өгөхийг Хан-Уул дүүргийн Насан туршийн суралцахуйн төв (Т.Рэгзэдмаа)-д, татан төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж, ажиллахыг Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс (Т.Оюунтуул)-т тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

*В.Оюумаа*

В.ОЮУМАА



115050097

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын  
 даргын 2024 оны 09 дүгээр сарын 05 -ны  
 өдрийн ААН дугаар тушаалын хавсралт

Данснаас хасах хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Хан-Уул дүүргийн Насан туршийн суралцахуйн төв

Д/д	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жижиг	Хэмжих жлгц	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдэрэл гэмтэл	ӨХБЗ- ийн дүгнэлт	Байгууллагын санал	Мэргэжлийн санал	ҮХХК-ын шигш
<b>1. Машин тоног төхөөрөмж</b>													
1	Усны аппарат	9	ш	1	327,273.0	327,273.00	327,273.00	-	эвдэрсэн	актлах	-	татах	татах
2	Зөөврийн компьютер HP	6	ш	1	1,499,900.0	1,499,900.00	1,499,900.00	-	эвдэрсэн	актлах	-	татах	татах
3	Зөөврийн компьютер Lenovo	9	ш	1	2,335,110.0	2,335,110.00	2,335,110.00	-	эвдэрсэн	актлах	-	татах	татах
4	Проектор	15	ш	1	828,000.0	828,000.00	828,000.00	-	эвдэрсэн	актлах	-	татах	татах
5	Ноос самнах машин	11	ш	1	500,000.0	500,000.00	500,000.00	-	эвдэрсэн	актлах	-	татах	татах
Тоног төхөөрөмжийн нийт дүн													
<b>2. Тавилга эд хогшил</b>													
1	Сандал	10	ш	1	308,000.0	308,000.00	308,000.00	-	хуучирсан	актлах	-	татах	татах
2	Самнах машин	10	ш	1	348,873.0	348,873.00	348,873.00	-	эвдэрсэн	актлах	-	татах	татах
3	Ээрэх машин	8	ш	1	343,959.0	343,959.00	343,959.00	-	эвдэрсэн	актлах	-	татах	татах
4	Гитар	6	ш	10	150,000.0	1,500,000.00	1,500,000.00	-	эвдэрсэн	актлах	-	татах	татах
Тавилга эд хогшил дүн													
<b>Нийт дүн</b>													
Үүнээс: Худалдан борлуулах хөрөнгө													
Татан төвлөрүүлэх													
Устгах хөрөнгө													
Худалдсанаас олох орлого													
НӨХГ-т төвлөрүүлэх /30 %/													